


БАТЛАВ.
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Х.ХЭРЛЭН



**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2018 ОНЫ АВЛИГЫН
ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хариуцах албан тушаалтан
ТУЛГУУР ЗАРЧИМ 1. ЁС ЗҮЙТЭЙ МАНЛАЙЛАЛ					
Зорилт 1. Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох					
1.	Удирдлагаас гаргаж буй шийдвэр, тухайн жилд тус агентлагийн үйл ажиллагаанд зарцуулахаар төсөвлөгдсөн санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, түүний хэрэгжилтийн талаар албан хаагчид, олон нийтэд ил тод, нээлттэй болгох; Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, Шилэн дансны тухай хууль, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2, 4 дүгээр зүйлийн 4.1.1.	Жилдээ	1. Энэхүү үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг байгууллагын дотоод дүрэм, журамд тусгайлсан заалт болгон оруулах буюу даргын тушаал гарган хэрэгжүүлэх; 2. Энэ талаар албан хаагчдад танилцуулсан, олон нийтэд цахим хуудас, мэдээллийн самбараар хүргэсэн байх; 3. Холбогдох хуулийн заалт, журам, тушаалыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих механизмыг бүрдүүлсэн байх; 4. Удирдлагын шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг улирал бүр албан хаагчдад мэдээлж хэвшүүлэх, олон нийтэд хамааралтай мэдээллийг тухай бүр хүргэж хэвших;	<ul style="list-style-type: none"> Удирдлагын шийдвэр, төсөв санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдлын зохицуулалт бүрэн хангагдсан байна. Удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих механизм бүрдсэн байна. 	Бүх хэлтэс, нэгжүүд
2.	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх;	Жилдээ	Авилгын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилт, тайлагналт, үр дүнд анхаарч ажиллах;	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамтын ажиллагааны оролцоог хангасан байна.	ЭБАТ
3.	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил	Жилдээ	1. Тухайн жилд явуулах хяналт,	Байгууллагын дотоод хяналт	Хяналт-

	<p>тод, нээлттэй байдлыг хангах;</p> <p>/Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3./</p> <p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.</p>		<p>шалгалтын төлөвлөгөөг гаргах;</p> <p>2. Хийсэн хяналт, шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх;</p> <p>3. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж/ холбогдох арга хэмжээ авсан байна.</p>	сайжирсан байна.	шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс.
4.	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлж ажиллах;</p> <p>/Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл/, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.</p>	Сар бүр болон хуулийн хугацаанд	Тухайн жилийн төсөв 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэл 04 дүгээр сарын 01-ний дотор, дараа жилийн төсөв 08 дугаар сарын 15-ны дотор цахим хуудсанд байршуулах;	Байгууллагын төсвийн ил тод байдлын сайжруулсан байх;	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
5.	<p>Байгууллагын чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах;</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8/, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2.</p>	Долоо хоног бүр	<p>1. Байгууллагаас тусгай зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаа, түүнийг олгоход шаардлагтай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд нээлттэй байлгах;</p> <p>2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны талаарх мэдээллийг цахим хуудсандаа тогтмол байршуулах;</p>	Иргэн, албан байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээний шуурхай байдал дээшилсэн нээлттэй ил тод болсон байна.	Кадастрын хэлтэс

ТУЛГУУР ЗАРЧИМ 2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ

Зорилт 2. Шударга ёс, эрхэмлэх зүйлс болон ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх

6.	<p>Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу ажиллах;</p> <p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.</p>	Жилдээ	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг журмын 02 дугаар хавсралтаар баталсан хүснэгтийн дагуу Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байх;	<ul style="list-style-type: none"> Агентлагын төрийн захиргааны албан хаагчдын ёс зүй дээшлсэн байх; Зөрчилгүй ажилласан байх; 	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс;
7.	Албан хаагч бүрийн ажил үүргийн	Жилдээ	Төрийн албан хаагч нэг бүрийн ажлын	Байгууллагын үйл	Төрийн

	хуваарийг тодорхой болгох; Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.		байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх;	ажиллагааны чадавхи дээшлэхэд дэмжлэг болсон байна.	захиргааны удирдлагын хэлтэс
8.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор ханган; Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.	Жилдээ	<ol style="list-style-type: none"> 1. Хүний нөөцийн сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах. /Тухай бүр шинэчлэх/ 2. Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; 3. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсаар ойлгомжтой байдлаар байршуулах; 4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх; 5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн үнэлэх; 	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байна.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
ТУЛГУУР ЗАРЧИМ 3. ТОГТОЛЦООНЫ ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ					
Зорилт 3. Төрийн байгууллагад мөрдөгдөж буй хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм, журмыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох ажлыг зохион байгуулах					
9.	Агентлагын үйл ажиллагаа, салбарын хэмжээнд мөрдөж байгаа дүрэм, журам, хуульд нийцсэн эсэхийг хянан үзэх, өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, холбогдох эрх бүхий байгууллагад шийдвэрлүүлэхээр санал хүргүүлэх, шинээр болон шинэчилэн боловсруулах дүрэм, журамд олон нийтийн, мэргэжлийн холбоодын саналыг тусгах боломжийг бүрдүүлэх; "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.	Жилдээ	<ol style="list-style-type: none"> 1. Жагсаалт гаргасан байх; 2. Дүрэм, журам, шийдвэрийг хянан үзсэн байх; 3. Өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх; 4. Холбогдох эрх бүхий байгууллагад саналаа тавьж шийдвэрлэсэн байх; 5. Байгууллагын вэб сайтаар дамжуулан олон нийт, мэргэжлийн холбоодтой харилцах боломжийг бүрдүүлэх; 	Иргэн, албан тушаалтанд үзүүлэх төрийн үйлчилгээний шуурхай болсон байх;	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс;
Зорилт 4. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх					
10.	Цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх;	Жилдээ	<ol style="list-style-type: none"> 1. Цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний жагсаалтыг гаргаж, цахим хэлбэрээр 	Иргэн, албан тушаалтанд үзүүлэх төрийн үйлчилгээний шуурхай байдалд бодит	Бүх хэлтэс, нэгжүүд

	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2.		<ul style="list-style-type: none"> үзүүлэхээр шийдвэрлэсэн байх; 2. Одоо үзүүлж буй үйлчилгээг боловсронгуй шуурхай болгох; 3. Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх; 	дэмжлэг болсон байх;	
11.	<p>Албан бичиг баримт хөтлөлтийн нээлттэй системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, иргэд аж ахуй нэгжийг агентлагийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих боломжоор хангах;</p> <p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2.</p>	Жилдээ	<ul style="list-style-type: none"> 1. Бичиг хэргийн хөтлөлтийн шинэ системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх; 2. Иргэд өөрийн гомдол хүсэлт шийдвэрлэлтийн явцыг шууд хянах боломжтой болох; 	Иргэн, албан тушаалтанд үзүүлэх төрийн үйлчилгээ шуурхай ил тод болсон байх;	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс;

Зорилт 5. Авлигын эсрэг ба авлига гарах боломжийг бууруулах

12.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах;</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.4;</p>	Жилдээ	<ul style="list-style-type: none"> 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах; 2. Тендерийн баримт бичиг, шалгаруулалтыг явуулах журам, урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулах; 3. Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон сонгон шалгаруулсан үндэслэлийн тухай бүр шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаар нээлттэй мэдээлэх; 4. Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл хуулийн үндэслэлийн талаар оролцогч нарт танилцуулах; 5. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах; 	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байна.	Бүх хэлтэс, нэгжүүд
-----	---	--------	--	--	---------------------


ТУЛГУУР ЗАРЧИМ 4. ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 6. Захиргааны хариуцлагын тогтолцоог үр дүнтэй ашиглах

13.	Байгууллагын соёл, үйлчилгээ, ажлын зохион байгуулалтын нээлттэй байдлын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг гаргуулах, дүгнэлт хийх нийтэд ил тод мэдээлэх;	Дөрөвдүгээр улиралд	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгч иргэд, аж ахуй нэгжээс байгууллагын үйл ажиллагааны талаар санал асуулга авах; 2. Санал асуулгын дүнд дүн шинжилгээ хийж үйл ажиллагаагаа сайжруулах арга хэмжээ авах, хариуцлага тооцох; 3. Энэ талаар албан хаагчдад танилцуулсан байх; 	Иргэн, албан байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээ шуурхай болсон байх, албан хаагчдын ёс зүй, ажлын хариуцлага дээшилсэн байх;	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс
14.	Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг татан оролцуулж хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх;	Жилдээ	Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг оролцуулж ажилласан байх;	Авлигаас ангид байх нөхцөл сайжирсан байна.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, ЭБАТ
15.	Сахилга дэг журам, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангуулах, албан хаагчдад тухай бүр танилцуулж хэвших;	Улирал бүр	<ol style="list-style-type: none"> 1. Гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж ажилласан байх; 2. Албан хаагчдад тухай бүр танилцуулж хэвшсэн байх; 	Захиргааны хариуцлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг хангах;	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Танилцсан:


Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга



Б.Дашпүрэв

Боловсруулсан:

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан



Б.Алтан-Очир